



**“ТОП МОТОРС” ХХК- ИЙН АВТО МАШИНЫ
ТЕХНИК ЭД АНГИЙН ЦЭВЭРЛЭГЭЭНИЙ БОДИС
БОЛОН АВТО БУДГИЙН АГУУЛАХ ТӨСЛИЙН
2026 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

АГУУЛГА

1. Төслийн танилцуулга.....	4
2. Төсөл хэрэгжиж буй нутгийн байгаль орчин, нийгэм эдийн засгийн төлөв байдлын товч танилцуулга	7
3. Төслийн гол ба болзошгүй нөлөөллийн товч тодорхойлолт	7
4. Байгаль орчныг хамгаалах хүрээ, зорилт, арга хэмжээ	10
5. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ.....	12
6. Ажилчдын эрүүл мэндэд учруулах сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ.....	12
7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	19
8. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	18
9. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах арга хэмжээний төлөвлөгөө.....	14
10. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	14
11. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	16
12. Онцгой үеийн бэлэн байдал болон хариу арга хэмжээ.....	17
13. Орчны ногоон байгууламжийн төлөвлөгөө	19
14. Байгаль орчны менежментийн төлөвлөнөөний зардал	22

ОРШИЛ

“Топ Моторс” ХХК нь (улсын бүртгэлийн дугаар: 9011811285) 2021 онд үүсгэн байгуулагдсан М-Си-Эс группын охин компани бөгөөд Монгол Улсын Toyota брэндийн албан ёсны дилер юм. Автомашин борлуулалт, албан ёсны засвар үйлчилгээ, оригинал сэлбэг, дагалдах хэрэгсэл, автомашин угаалга, оношилгоо чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг.


Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөг компанийн байгаль орчны бодлого, төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ, байгаль орчин, аялал жуулчлалын сайдын сайдын 2019 оны 10 сарын 29-ний өдрийн А-618 дугаар тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ыг үндэслэн боловсруулав.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэх бөгөөд байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд сөрөг нөлөөллийг бууруулах, арилгахтай холбогдсон арга хэмжээг тодорхойлон, шаардагдах хөрөнгө зардлыг тооцож, хариуцах этгээд, хэрэгжүүлэх хугацаа, баримтлах хууль, журам, аргачлал, стандартыг тодорхойлж тусгасан болно.

1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

1.1. Төслийн ерөнхий мэдээлэл

Төслийн нэр	“Автомашинны техник эд ангийн цэвэрлэгээний бодис болон авто будгийн агуулах”
Төсөл хэрэгжүүлэгч	“Топ моторс” ХХК, улсын бүртгэлийн дугаар: 9011811285, регистрийн дугаар: 6472486
Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг	Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 6 дугаар хороо, 10 дугаар хороолол, энхтайваны өргөн чөлөө, 51/1 Тоёото, Топ моторс төв, Утас: 77778090
Төслийн байршил	Нийслэлийн Баянгол дүүргийн 6 дугаар хорооны нутагт Топ моторс ХХК-ийн өөрийн байранд байрлана




Зураг 1. Төслийн талбайн байршил



Зураг 2. Төсөл хэрэгжих орчны харагдах байдал

1.2. Төслийн хүчин чадал

“Топ моторс” ХХК-ийн “Автомашины техник эд ангийн цэвэрлэгээний бодис болон авто будгийн агуулах” төслийн хүрээнд нийт 18 нэр төрлийн бодис, бүтээгдэхүүнийг хадгалах, ашиглах бөгөөд 2 төрлийн цэвэрлэгээний бодис, 16 төрлийн авто машины будаг болон будаг шингэлэгч байна. PDU - 200, PDU -201 цэвэрлэгээний бодис нь Испани улсад үйлдвэрлэгдсэн чанарын шаардлага хангасан бүтээгдэхүүн юм. Автомашины будгийн бүтээгдэхүүнүүд нь Хятад үйлдвэрлэгдсэн чанарын шаардлага хангасан бүтээгдэхүүн юм. Эдгээр химийн бодисуудыг Байгаль орчин, Уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдөр олгосон 0000187 тоот “Химийн хорт болон аюултай бодис импортлох, ашиглах тусгай зөвшөөрөл”- ийн хүрээнд үйл ажиллагаандаа ашиглаж байгаа болно.




Зураг 3. Агуулах-1 Багтаамж 36т²



Зураг 4. Агуулахын агааржуулалт



Зураг 5. Цэвэрлэгээний төхөөрөмж



Зураг 6. Төхөөрөмжийн танилцуулга



Зураг 7. Автомашины будаг агуулах –2
Багтаамж –40т²



Зураг 8. Агуулахын үүдний хэсэг



Зураг 9. Будаг найруулах хэсэг



Зураг 10. Будаг найруулах хэсэг

2. ТӨСӨЛ ХЭРЭГГИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

2.1. Нийгэм эдийн засгийн төлөв байдал

Төсөл хэрэгжих талбай нь Улаанбаатар хотын Баянгол дүүргийн 6 дугаар хороо, суурьшлын бүсийн нутаг дэвсгэрт байршина. Баянгол дүүргийн 6-р хороо нь Улаанбаатар хотын төв хэсэгт, 10-р хорооллын зүүн хойд хэсэг буюу UB Palace орчимд байрладаг, хүн амын өндөр нягтралтай, худалдаа үйлчилгээ төвлөрсөн хотжилт өндөртэй бүс юм. 2024 оны байдлаар тус хороонд 10,677 иргэн оршин сууж байна.

2.2. Байгаль орчны төлөв байдал

Улаанбаатар хот, түүний орчмын нутаг дэвсгэр нь Монгол орны физик газарзүйн мужлалаар Хэнтийн уулархаг мужийн баруун урд үзүүрт Туул голын хөндийн 2.5-4 км хүртэл өргөсөж тохойрсон татам болон дэнжийн хэсэгт байрладаг. Газарзүйн байршлын хувьд ойт хээрийн бүсэд багтдаг бөгөөд 1950-2268 м үнэмлэхүй өндөртэй Богдхан, Сонгинохайрхан, Чингэлтэй, Баянзүрх зэрэг өндөр уулсаар хүрээлэгдэнэ. Төсөл хэрэгжих газрын орчимд ердийн хар хүрэн, нугат хар хүрэн хөрс зонхилон тархсан байна. Төслийн ойр орчмын барилгажсан талбайд ердийн хар хүрэн ба сайргархаг хар хүрэн хөрс тархана. Төсөл хэрэгжих газар нь Монгол Улсын усны сав газрын ангиллаар Туул голын сав газарт багтана. Туул гол нь Хан Хэнтий нурууны салбар уулс болох далайн түвшнээс дээш 2000м өндөрт өргөгдсөн Чисаалайн сарьдаг, Шороотын давааны өврөөс гарах Намъяа, Нэргүй хэмээх хоёр голын уулзвараас эх авна. Хэнтий нурууны салбар уулсаас эх авсан Галттай, Сарьдгийн Хийд, Хаг, Хонгор, Зүүн Баян, Тэрэлж, Хөлийн гол, Улиастай, Сэлбэ, Хар бух зэрэг гол горхи Туулд цутгана. Гулдралын дундаж өндөр 1160 м, ус хагалбарын шугамын урт 2055.6 км, түүний дундаж өндөр 1719.0 м, голуудын нийлбэр урт 11046.5 км, усан сүлжээний нягтшил 0.23 км/км², ус хурах талбайн дундаж өндөр 1300.0 м, хөндийн гүн дунджаар 559.0 м, түүний өргөн 54.4 км, сав газрын суналтын зэрэг 16.5, ус хагалбарын шугамын хөгжлийн зэрэг 2.6, хажуугийн хэрчигдэл 0.8 байна.

3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Төслийн тухайн нутаг дэвсгэр, бүс нутгийн байгаль орчинд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийг 2024 онд байгаль орчны төлөв байдлын үнэлгээ болон нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээнд тодорхойлсон байдаг.

3.1. Төслийн болзошгүй сөрөг нөлөөлөл

Төслийн болзошгүй нөлөөллийг тогтоохдоо магадлан жагсаах аргыг ашиглаж, үнэлгээг Хүснэгт 1-д хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 1. Төслийн болзошгүй сөрөг нөлөөллийн үнэлгээ

Байгаль орчны үзүүлэлтүүд	Нөлөөлөхгүй	Нөлөөлөл			Хугацаа		Давталт		Эрчим		
		Шууд	Шууд бус	Өөрөө зохицуулах	Богино хугацааны	Урт хугацааны	Буцаж нөлөөлөх	Буцалтгүй нөлөөлөх	Хүчтэй	Дунд зэрэг	Бага зэрэг
1. Байгалийн экосистемийн өөрчлөлт											
Газрын доорх урсцын өөрчлөлт	X										
Хөрсний элэгдэл, эвдрэл	X										

Ургамлын бүтцийн өөрчлөлт	X									
Зэрлэг амьтдын орон зай	X									
Уур амьсгалын бичил өөрчлөлт	X									
2. Байгалийн нөөц ашиглалт										
Газрын гадаргын усны нөөц	X									
Эрчим хүчний нөөц	X									
3. Байгаль орчны чанарын өөрчлөлт										
Газрын доорх усны чанарын өөрчлөлт	X									
Агаарын бохирдол		X			X					X
Хөрсний бохирдол	X									
Дуу чимээ, шуугианы нөлөө	X									
4. Байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палеонтологийн олдвор										
Байгалийн үзэсгэлэнт өнгө төрх	X									
Ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх	X									
Тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх	X									
Түүх соёлын дурсгалт зүйлд нөлөөлөх	X									
Археологи, палеонтологийн олдворт нөлөөлөх	X									
5. Эдийн засаг, нийгмийн асуудал										
Ажлын байр нэмэгдэх		X				X		X		X
Хувийн өмчийн болон татварын орлого		X				X		X		X
Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох		X			X			X		X
Улирлын чанартай эрэлт хэрэгцээ		X				X		X	X	
Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх			X			X		X		X
Дүн	15	5	1		2	4		5	1	5

3.2. Төслийн гол сөрөг нөлөөлөл

Төслийн гол сөрөг нөлөөллийн үнэлгээг байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг тус бүрээр оноот үнэлгээний аргаар тус тус үнэлсэн бөгөөд төслийн үйл ажиллагаанаас агаарын чанар, газрын гадарга, хэвлий, хөрсөн бүрхэвч, биологийн олон янз байдалд нөлөөлөл үзүүлэхгүй. Нийт гол сөрөг нөлөөллийн үнэлгээг нэгтгэн үзэхэд **дунд зэргийн эерэг нөлөөтэй гэж үнэлэгдсэн**. Гол сөрөг нөлөөллийн үнэлгээний нэгтгэлийг Хүснэгт 2-оор үзүүлэв.

Хүснэгт 2. Төслийн гол сөрөг нөлөөллийн үнэлгээ

№	Нөлөөлөл	Нөлөөллийн түвшин	Нөлөөллийн үнэлгээ
A	Физик нөлөөлөл	-6	Бага сөрөг
A1	Агаарын чанар	-6	Бага сөрөг
A2	Газрын гадарга, хэвлий	0	Нөлөөлөхгүй
A3	Хөрсөн бүрхэвч	0	Нөлөөлөхгүй
A4	Ус	0	Нөлөөлөхгүй
B	Биологийн олон янз байдал	0	Нөлөөлөхгүй
B1	Ургамлан нөмрөг	0	Нөлөөлөхгүй
B2	Амьтны аймаг	0	Нөлөөлөхгүй
C	Нийгэм-Эдийн засгийн нөлөөлөл	+14	Дунд зэргийн эерэг
	Нийт нөлөөлөл	+10	Дунд зэргийн эерэг нөлөөтэй

- **Байгалийн баялаг, нөөц ашиглалт**

- “Автомашинны техник эд ангийн цэвэрлэгээний бодис болон авто будгийн агуулах” төслийн хүрээнд ахуйн хэрэгцээнд ашиглагдах усыг төвийн шугамаас хангах ба дулааныг мөн төвийн шугамаас хангана.

- **Байгаль орчны чанарын өөрчлөлт**

- Будагч бодис нь дотоод орчны агаарт нөлөөхөөс гадна агааржуулалттай учир гадаад орчны агаарт шууд, богино хугацаанд бага зэрэг нөлөөлнө.
 - **Байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палеонтологийн олдвор**
- Төсөл хэрэгжих талбай нь тусгай хамгаалалттай бүс нутагт оршдоггүй. Төсөл хэрэгжих газрын орчимд түүх соёлын дурсгалт зүйлс илрээгүй.
 - **Усны чанарт үзүүлэх нөлөөллүүд**
- Төслийн хүрээнд ахуйн хэрэгцээнд ашиглагдах усыг төвийн шугамаас хангах учир гадаргын болон газар доорх усанд нөлөөлөл үзүүлэхгүй.
 - **Биологийн олон янз байдалд үзүүлэх нөлөөллүүд**
- Төслийн хүрээнд шинээр газар шорооны ажил хийгдэхгүй учир амьтны аймагт нөлөөлөл үзүүлэхгүй.
 - **Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх нөлөөллүүд**
- Төслийн хүрээнд шинээр газар шорооны ажил хийгдэхгүй бөгөөд Баянгол дүүргийн 6 дугаар хороо, суурьшлын бүс, өөрийн эзэмшлийн байранд 79м2 талбайг ашигладаг. Уг талбай нь гадуураа хатуу хучилттай замтай, барилга дотор, төвийн шугаманд холбогдсон болно. Иймд газрын гадарга, хэвлийд нөлөөлөл үзүүлэхгүй.
 - **Ургамлан бүрхэвчинд үзүүлэх нөлөөллүүд**
- Төслийн хүрээнд шинээр газар шорооны ажил хийгдэхгүй учир ургамлан нөмрөгт нөлөөлөл үзүүлэхгүй.
 - **Эдийн засаг нийгмийн асуудал**
- Төсөл хэрэгжсэнээр ажлын байр нэмэгдэж, иргэдийн амьжиргааны түвшин дээшилж ядуурлыг бууруулахад дэмжлэг болох, үйл ажиллагааны туршид улс, орон нутгийн төсөвт татвар төлснөөр дүүргийн орлого нэмэгдэх зэрэг эерэг нөлөөллүүд урт хугацаанд, шууд хэлбэрээр нөлөөлнө.

4. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ХАМРАХ ХҮРЭЭ, ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

Төслийн 2026 оны Байгаль орчныг хамгаалах ажлын төлөвлөгөөг 2024 онд “Нандин байгаль” ХХК-ийн боловсруулсан “Топ моторс” ХХК-ийн “Автомашинны техник эд ангийн цэвэрлэгээний бодис болон авто будгийн агуулах” төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тодорхойлогдсон төсөл хэрэгжүүлэгчийн хүлээх үүргээс гадна Монгол Улсын Байгаль орчны багц хууль, холбогдох дүрэм журам, стандартуудын шаардлагуудыг мөрдлөг болгон тус төлөвлөгөөнд тусгагдсан үүрэг даалгавруудыг биелүүлэхийг зорилго болгосон. “Топ моторс” ХХК нь жил бүр байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулж, холбогдох төрийн байгууллагуудад тайлагнаж, биелэлтийг ханган ажиллана. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь дараах үндсэн 8 бүлэгтэй байна. /Хүснэгт 3/

Хүснэгт 3. Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төрөл	Тайлбар
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Агаар, ус, хөрсөнд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлнэ.
2	Ажилчдын эрүүл мэндэд учруулах сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ	Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ (БОННУ)-д тусгагдсан зөвлөмж, шаардлагын дагуу төслийн үйл ажиллагаанаас ажилчдын эрүүл мэндэд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх, арилгах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлнэ.
3	Хог хаягдлын менежмент	Энгийн болон аюултай хог хаягдлыг ангилан ялгах, түр хадгалах, тээвэрлэх, дахин боловсруулах болон устгахтай холбоотой менежментийн бүх арга хэмжээг төлөвлөгөөнд тусгана
4	Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ	Жил бүр хуулийн нийцлийг хангах хүрээнд авдаг зөвшөөрөл, тайлан, холбогдох бичиг баримтууд, байгаль орчны сургалт, мөн дүүргийн Засаг захиргааны нэгжтэй хамтран ажиллах үйл ажиллагааг тусгана.
5	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлаг арга хэмжээний төлөвлөгөө	Төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт, биелэлтийн тайланг хороо дүүргийн иргэд болон холбогдох төрийн байгууллагад тогтмол танилцуулах үйл ажиллагааг төлөвлөнө.
6	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	Гадаад болон дотоод орчны агаарын чанарт тогтмол хяналт-шинжилгээ хийх зорилгоор тогтоосон цэгүүдээс сорьц авч, итгэмжлэгдсэн мэргэжлийн лабораториор шинжилгээ хийлгэх ажлыг төлөвлөн хэрэгжүүлнэ.
7	Осол эрсдэлийн менежмент	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангах, БОННУ-д тодорхойлсон эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор осол, эрсдэлийн удирдлагын арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлнэ.
8	Орчны ногоон байгууламжийн төлөвлөгөө	Төслийн талбайн орчны тохижилт, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг сааруулах зорилгоор ногоон

	байгууламжийн төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлнэ.
--	--

Төслийн 2025-2029 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардлыг 2024 онд Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн ямаар батлагдсан байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд дараах байдлаар тодорхойлсон байдаг. /Хүснэгт 4/

Хүснэгт 4. Төслийн БОМТ-ын зардал, 5 жилээр

№	Зардлын төрөл	Нийт дүн /мян.төг/				
		2025 он	2026 он	2027 он	2028 он	2029 он
1	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө	4,650.0	7,250.0	4,650.0	6,750.0	4,150.0
1.1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	200.0	-	200.0	-	200.0
1.2	Ажилчдын эрүүл мэндэд учруулах сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ	1,750.0	1,750.0	1,750.0	1,750.0	1,750.0
1.3	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	200.0	-	200.0	-	200.0
1.4	Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөө	2,500.0	2,500.0	2,500.0	2,000.0	2,000.0
1.5	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах арга хэмжээ	-	3,000.0	-	3,000.0	-
2	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	500.0	500.0	500.0	500.0	500.0
	Дотоод болон гадаад орчны агаарын чанар	500.0	500.0	500.0	500.0	500.0
Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал /мян.төг/		5,150.0	7,750.0	5,150.0	7,250.0	4,650.0

5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Нэгж зардал, ₮	Нийт зардал, ₮	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Хариуцагч
5.1 Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ							
5.2.1	Төсөл хэрэгжих хугацаанд усны нөөц ашиглах	Ус ашигласны төлбөрийг тоолуурын дагуу тооцож төлөх	Төслийн хүрээнд	Үйл ажиллагааны зардалд тусгагдсан.		Сар бүр	Төсөл хэрэгжүүлэгч
5.2.2	Хаягдал ус	Төслийн ариун цэврийн өрөөний крантны бүрэн бүтэн байдлыг хангаж ус алдуулахгүй байх	Угаалтуур	-	-	Тухай бүрд	Төсөл хэрэгжүүлэгч

6. АЖИЛЧДЫН ЭРҮҮЛ МЭНДЭД УЧРУУЛАХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ, АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭ

№	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээний зорилго	Хамрах хүрээ	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Нэгж зардал, ₮	Нийт зардал, ₮	Хариуцагч	Баримтлах хууль журам, стандарт, аргачлал
6.1	Ажилчдыг зориулалтын иж бүрэн хувцас, бээлий, малгайгаар хангах, хангахдаа MNS6654:2017 стандартыг баримтлах	Аюулгүй ажиллагаа	2 ажилчин / 1 ээлж	Иж бүрэн	150'000	750'000	ХАБЭА хариуцсан ахлах ажилтан	MNS 6654:2017
6.2	Бүх ажиллагсдыг мэргэжлийн өвчнөөс урьдчилан сэргийлэх болон хугацаат эрүүл мэндийн үзлэгт хамруулах	Ажилчдын эрүүл мэндийг хамгаалах	2 ажилчин	Жилд 1 удаа	200'000	1'000'000	ХАБЭА хариуцсан ахлах ажилтан	Хөдөлмөрийн тухай хууль, ХАБЭА-н тухай хууль

6.3	Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сурталчилгааг тогтмол хийж байх, “Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгаа”-тай ажилчид танилцаж, үйл ажиллагаандаа хэрэгжүүлж хэвшүүлэх	Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа	Сэлбэг, засвар үйлчилгээний албаны ажилчид	Өдөр бүр	-	-	ХАБЭА хариуцсан ахлах ажилтан	MNS 4969:2000
6.4	Ажилчдад өглөө бүр аюулгүй ажиллагааны зааварчилгааг өгч, ажилтныг аюулгүй ажиллах арга барилд байнга сургаж байх	Аюулгүй ажиллагаа	Сэлбэг, засвар үйлчилгээний албаны ажилчид	Өдөр бүр	-	-	ХАБЭА хариуцсан ахлах ажилтан	MNS 4969:2000
6.5	Үйлдвэрлэлийн эрүүл ахуй. хөдөлмөрийн нөхцөл, түүний ангилал, хүчин зүйл, хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ MNS 5080:2001” стандартыг мөрдөж ажиллах	Хөдөлмөрийн аюулгүй байдал	Сэлбэг, засвар үйлчилгээний албаны ажилчид	Тогтмол	-	-	ХАБЭА хариуцсан ахлах ажилтан	MNS 5080:2001

7. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Нэгж зардал, ₮	Нийт зардал, ₮	Хариуцагч	Баримтлах хууль журам, стандарт, аргачлал
9.1	Хатуу хог хаягдал	Хатуу хог хаягдал цуглуулах хогийн савтай байх	“Автомашинны техник эд ангийн	1 ш	-	200’ 000	Захиргааны ажилтан	“Хог хаягдлын тухай хууль”
9.3	Ахуйн хатуу хог хаягдал орчныг бохирдуулах	Хог хаягдал цуглуулах хогийн савны хогийг тогтмол хугацаанд зөвшөөрсөн цэгт хаяж байх	цэвэрлэгээний бодис болон авто будгийн агуулах”-ын өрөөнд	Тогтмол	Холбогдох байгууллагатай хийсэн гэрээнд заасан төлбөрийн хэмжээгээр		Захиргаа, хүний нөөцийн алба, БОНЗ хороо	“Хог хаягдлын тухай хууль”

8. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Хэрэгжүүлэх хуваарь						Хариуцсан албан тушаалтан	Нийт зардал, ₮	Тайлбар
		2026 он								
		Сар 1-2	Сар 3-4	Сар 5-6	Сар 7-8	Сар 9-10	Сар 11-12			
10.1	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулж жил бүр батлуулж байх							ХАБЭА хариуцсан ахлах ажилтан	-	Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дүгээр сарын 29-ний өдрийн А/618 дугаар тушаал
	Ажилчдын сургалт тогтмол зохион байгуулах <ul style="list-style-type: none"> - Байгаль орчныг хамгаалах - Гал түймрээс урьдчилан сэргийлэх /шаардлагатай үед гал унтраах багаж хэрэгслийг ашиглаж чаддаг байх/ - Хөдөлмөр хамгаалал - Тогтвортой хөгжлийн зорилтуудыг танилцуулах зэрэг сэдвээр 							ХАБЭА хариуцсан ахлах ажилтан	500’000	

10.2	Төслийн талбай орчмын иргэдийн санал хүсэлтийг харгалзан хорооны иргэдэд тулгамдаж буй асуудлыг шийдэхэд дэмжиж туслах							БОНЗ хороо	2'000.000	Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 1 р сарын 06 ны өдрийн А 03 тоот журам
10.3	Ус, цахилгаан ашигласны болон бусад төлбөрийг төлөх							Нягтлан бодогч	Үйл ажиллагааны зардалд тусгагдсан.	Усны тухай хуулийн дагуу жил бүрийн холбогдох нийцлийг хангах
10.4	Ажилчдын сургалт тогтмол зохион байгуулах -Шинэ ажилчдын сургалт -Байгаль орчныг хамгаалах -Гал түймрээс урьдчилан сэргийлэх /шаардлагатай үед гал унтраах багаж хэрэгслийг ашиглаж чаддаг байх/ -Хөдөлмөр хамгаалал -Тогтвортой хөгжлийн зорилтуудыг танилцуулах зэрэг сэдвээр							ХАБЭА хариуцсан ахлах ажилтан	100.000	Сургалтын төлөвлөгөө гаргаж, бүртгэл хөтлөх
10.5	Эрүүл мэндийг хамгаалах -Эмийн сан, яаралтай тусламжийн багаж хэрэгсэл бий болгох							ХАБЭА хариуцсан ахлах ажилтан	-	Хөдөлмөрийн аюулгүй байдлын тухай хуулийн дагуу нийцлийг хангах
10.6	Төслийн үйл ажиллагаатай холбогдуулан дүүргийн болон хорооны холбогдох төр захиргааны байгууллагатай хамтран ажиллах							БОНЗ хороо		
10.7	Байгаль орчны төлөвлөгөөт аудитыг мэргэжлийн байгууллагаар хийлгүүлэх							ХАБЭА хариуцсан ахлах ажилтан	2.000.000	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн дагуу нийцлийг хангах

9. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	БОМТ-ийн биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
11.1	Дүүргийн байгаль орчны газар	Албан хүсэлт, Танхим	2026 оны Байгаль орчны менежмент төлөвлөгөөний гүйцэтгэлийг танилцуулах	2026 оны 11-р сард	ХАБЭА хариуцсан ахлах ажилтан	Дүүргийн байгаль орчны газар
11.2	Бүх шатны Засаг дарга, Байгаль орчны улсын байцаагч, орон нутгийн байцаагч	Хуралд танилцуулах, Уулзалт	2026 оны Байгаль орчны менежмент төлөвлөгөөний тайлан, 2027 оны төлөвлөгөө танилцуулах	2026 оны 12-р сарын 1-ийн дотор	ХАБЭА хариуцсан ахлах ажилтан	Дүүрэг, хорооны танхим Улаанбаатар хот
11.3	Төрийн бус байгууллага, олон нийт	Албан хүсэлт, и-мэйлээр		2026 оны 12-р сарын 1-ийн дотор	ХАБЭА хариуцсан ахлах ажилтан	
11.4	Төрийн захиргааны төв байгууллага	Тайлан, төлөвлөгөөг цаасан хэлбэрээр		2026 оны 12-р сарын 10-ын дотор	ХАБЭА хариуцсан ахлах ажилтан	Төрийн захиргааны төв байгууллагын байранд

10. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Нэгж зардал, ₮	Нийт зардал, ₮	Хариуцагч	Баримтлах хууль журам, стандарт, аргачлал
11.1 Агаарын чанарын хяналт шинжилгээ							
12.1.1	<ul style="list-style-type: none"> - Хүхэрлэг хий (SO₂) - Азотын ислүүд (NO_x) - PM 2.5 - PM10 - TSP нийт тоос - Нүүрстөрөгчийн дутуу исэл (CO) 	“Автомашинь техник эд ангийн цэвэрлэгээний бодис болон авто будгийн агуулах”-ын өрөөнд	Жилд 2 удаа 5,10 сард	100.000	500.000	ХАБЭА хариуцсан ахлах ажилтан	<p>MNS 4585-2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага, MNS 3384:1982 Сорьц авахад тавих ерөнхий шаардлага, MNS 4048:1988 Тоосны хэмжээг тодорхойлох жингийн арга</p> <p>MNS 0017-2-5-11:1988 Агаар дахь азотын давхар ислийн хэмжээг тодорхойлох фотоколориметрийн арга,</p>

11. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ


№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Хариуцагч
8.1	Химийн бодис ашиглах явцад осол гарах	Химийн ослоос урьдчилан сэргийлэх, ослын үед ажиллах төлөвлөгөөг боловсруулах	“Автомашинны техник эд ангийн цэвэрлэгээний бодис болон авто будгийн агуулах”-ын ажилчид	Жил бүр	ХАБЭА хариуцсан ахлах ажилтан
		Химийн ослоос урьдчилан сэргийлэх, ослын үед ажиллах төлөвлөгөөг ажилчдад танилцуулах, сургалт орох		Жил бүр	
8.2	Химийн бодисын буруу ашиглалтаас үүдэн осол гарах	Химийн бодисыг Хор аюулын лавлан мэдээллэх хуудсанд заасан нөхцөлд хадгалах		Тогтмол	
		Химийн бодисын агуулахын тэмдэг тэмдэглэгээг байршуулах		Тухай бүр	
8.3	Ажиллагсдыг сургалт мэдээллээр хангаагүйн улмаас осолд өртөх	Химийн бодистой харьцан ажиллагсдад сургалт зохион байгуулах		Жил бүр	
8.4	ХАБЭА-н зааварчилгааг хангалтгүй биелүүлсэн тохиолдолд өөрт болон бусдын эрүүл мэнд, байгаль орчинд хохирол учруулах.	ХАБЭА-н аюулгүй ажиллагааны зааварчилгааг тогтмол ажлын өмнө өгөх		Өдөр бүр	
8.5	Галын болзошгүй аюул эрсдэл	Галын эрсдэлээс сэргийлэх практик болон онолын сургалтыг онцгой байдалтай хамтран нийт ажилтнуудад орох		Жил бүр	

12. ОНЦГОЙ ҮЕИЙН БЭЛЭН БАЙДАЛ БОЛОН ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ

- 13.1 Байгаль орчны бохирдол үүсгэж болзошгүй аливаа ослоос урьдчилан сэргийлэх, ослын үед шуурхай хариу арга хэмжээ авах үйл ажиллагааг компанийн “Гамшгаас хамгаалах төлөвлөгөө”-өөр зохицуулна.
- 13.2 Байгаль орчны зөрчил гарсан тохиолдолд, мөн урьдчилан сэргийлэх зорилгоор ажилчид илэрсэн эрсдэл, аюулыг “Аюулыг мэдээлэх хуудас”-аар дамжуулан тухай бүр мэдээлнэ.

13. ОРЧНЫ НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн барилгын орчны ногоон байгууламжийн төлөвлөлтийн хүрээнд байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, бичил уур амьсгалыг сайжруулах, тоосжилт болон дуу чимээний нөлөөг сааруулах зорилгоор Топ Моторс ХХК ны тэрбум мод үндэсний хөдөлгөөнд нэгдэн ойжуулья, нөхөн сэргээе, арчилъя аяны хүрээнд 2023 оноос 150 ширхэг мод тарьсан. Бид энэ онд уг аяны хүрээнд нийт 230 ширхэг хайлаас модыг 2026 онд тарихаар төлөвлөсөн. Мод тарих байршил, талбайн ерөнхий төлөвлөлт, зохион байгуулалтыг Зураг 11-д үзүүлсэн болно. Мөн таригдах модны төрөл зүйл, тоо хэмжээ, байршлын дэлгэрэнгүй мэдээллийг Хүснэгт 5-д харуулав. Ногоон байгууламжийн арчилгаа, усалгаа, нөхөн сэргээлтийг тогтмол хийж, тарьсан моддын ургалт, амьдралтын түвшинг хангах арга хэмжээг хэрэгжүүлнэ.



Мод тарих хэсэг

Зураг 11. Ногоон байгууламжийн төлөвлөлт



Хүснэгт 5. Тарих модны тоо хэмжээ

Мод тарих байршил	Модны төрөл	Тоо ширхэг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Нэгж зардал, ₮	Нийт зардал, ₮	Хариуцагч
“Топ моторс” ХХК-ийн гадна нийтийн эзэмшлийн талбайд	Хайлаас	200	5-р сард	-	-	

“Топ моторс” ХХК-ийн гадна нийтийн эзэмжшлийн талбайн цэцэрлэг	Хайлаас	30	9-р сард	-	-	“Топ моторс” ХХК-ийн ажилчид, БОНЗ хороо
--	---------	----	----------	---	---	--

14. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗАРДАЛ

2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нийт 8 бүлгийн хүрээнд 36 арга хэмжээ, ажлыг төлөвлөсөн. Тус төлөвлөгөөг хэрэгжүүлэхтэй холбоотой зардлыг Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ (БОННУ)-д тусгагдсан тооцоо, шаардлагын дагуу боловсруулж, дараах байдлаар төлөвлөв.

Хүснэгт 6. БОМТ-ын зардал, 2026 он

№	Зардлын төрөл	Нийт дүн, төгрөг
1	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө	
1.1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	-
1.2	Ажилчдын эрүүл мэндэд учруулах сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ	1.750.00
1.3	Орчны ногоон байгууламжийн төлөвлөгөө	-
1.4	Осол эрсдлийн менежмент	-
1.5	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	-

1.6	Удирдлага-зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөө	2.500.000
1.7	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах арга хэмжээний төлөвлөгөө	3.000.000
2	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	
2.1	Дотоод болон гадаад орчны агаарын чанар	500.000
Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал, төгрөг		7.750.000